**2024 он**

**“ТАВАНТОЛГОЙ ТҮЛШ” ХХК**

# ЦАХИЛГААНЫ МАТЕРИАЛ ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

| | |
|---|---|
| Тендер шалгаруулалтын нэр: | “Цахилгааны материал” худалдан авах |
| Тендер шалгаруулалтын дугаар: | ТТТХХК20240102229 |

# I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ) ..................................... 1
1. Тендерийн цар хүрээ ..................................... 1
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг ..................................... 1
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж ..................................... 1
4. Сонирхогч этгээд, оролцогч ..................................... 2
5. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ ..................................... 2
6. Нийлүүлэх барааны гарал үүсэл ..................................... 2
7. Тендер шалгаруулалтын баримт бичиг ..................................... 3
8. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах ..................................... 3
9. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт ..................................... 3
10. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл ..................................... 3
11. Тендерийн иж бүрдэл ..................................... 4
12. Тендерийн жишиг маягтууд ..................................... 5
13. Хувилбарт санал ..................................... 5
14. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг ..................................... 5
15. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг ..................................... 5
16. Чадавхын болон туршлагын шаардлага ..................................... 7
17. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ..................................... 7
18. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ..................................... 8
19. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт ..................................... 8
20. Тендерийн валют ..................................... 9
21. Тендер хүчинтэй байх хугацаа ..................................... 9
22. Тендерийн баталгаа ..................................... 9
23. Тендер баталгаажуулах, илгээх ..................................... 9
24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа ..................................... 10
25. Тендерийн талаар тодруулга авах ..................................... 10
26. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх ..................................... 10
27. Тендерийг үнэлэх ..................................... 10
28. Арифметик алдааг залруулах ..................................... 10
29. Оролцогчид давуу эрх олгох ..................................... 11
30. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт ..................................... 11
31. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох ..................................... 11
32. Тендерийг эрэмбэлэх ..................................... 11
33. Оролцогчийн чадавхыг дахин магадлах ..................................... 11
34. Мэдэгдэл хүргүүлэх ..................................... 11
35. Гүйцэтгэлийн баталгаа ..................................... 12
36. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах ..................................... 12

## I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

### А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

| | | |
|---|---|---|
| **1. Тендерийн цар хүрээ** | 1.1. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид "**Хууль**" гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид "**бараа**" гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана. |
| | 1.2. | Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана. |
| | 1.3. | Барааг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой багцын барааг хуулийн 8.1-д зааснаар дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой бол энэ тухай захиалагч өгөгдлийн хүснэгтэд заана. Ийнхүү заасан бол тендер шалгаруулалт, эсхүл түүний багцад зөвхөн Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлнэ. |
| | 1.4. | Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгт болон зарлалд заана. |
| **2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг** | 2.1. | Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана. |
| **3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж** | 3.1. | Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө. |
| **4. Худалдан авах ажиллагааны цахим систем** | 4.1. | Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид "цахим систем" гэх/-ээр зохион байгуулна. |
| **5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх** | 5.1. | Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ. |

| | | |
|---|---|---|
| | 5.2. | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20[1], 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна. |
| **6. Сонирхогч этгээд, оролцогч** | 6.1. | Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ. |
| | 6.2. | Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна. |
| | 6.3. | Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй. |
| | 6.4. | Тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан үйлчилгээний хураамж төлсөн байна. |
| | 6.5. | ТШЗ-ны 6.4-т заасан үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй. |
| **7. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ** | 7.1. | Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна. |
| | 7.2. | Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй. |
| | 7.3. | Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна. |
| | 7.4. | ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй. |
| | 7.5. | Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ. |
| **8. Нийлүүлэх барааны гарал үүсэл** | 8.1. | ТШЗ-ны 1.3-т өөрөөр заагаагүй бол гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно. |

## Б.АГУУЛГА

**9. Тендер шалгаруулалтын баримт бичиг**

9.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;
II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;
III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;
IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;
V Бүлэг. Тендерийн жишиг маягт;
VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

9.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

9.3. Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.

**10. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах**

10.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтийг хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиалагчид гаргах бол Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүргүүлнэ.

10.2. ТШЗ 10.1-д заасан хүсэлтэд ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана.

10.3. Тодруулгын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл захиалагч хуулийн 20.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.

**11. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**

11.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана. Захиалагч уулзалтад ТШЗ-ны 6.6-д заасан сонирхогч этгээд, түүний төлөөллийг оролцуулна.

11.2. ТШЗ-ны 11.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аж ахуй эрхлэгчийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

## B. ТЕНДЕР БЭЛТГЭХ

**12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл**

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 12.1-д заасан хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны 12.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендер шалгаруулалтын баримт бичгийг баримтална.

12.4. Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

**13. Тендерийн иж бүрдэл**

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн бараа нийлүүлэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. захиалагч зөвшөөрсөн бол ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. санал болгож буй бараа ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.6. бараа нийлүүлэлтийн хуваарь;

13.2.7. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 18, ТШЗ 19, ТШЗ 20 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.8. ТШЗ-ны 21 дүгээр зүйлд заасан барааны үнийн задаргаа;

13.2.9. ТШЗ-ны 21.9-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.10. түншлэл бол хуулийн 6.3-т заасан түншлэлийн гэрээ.

| | |
|---|---|
| | 13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна. |
| | 13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ. |
| **14. Тендерийн жишиг маягтууд** | 14.1. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтын дагуу илгээнэ. |
| **15. Хувилбарт санал** | 15.1. Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерт ирүүлж болно. |
| **16. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг** | 16.1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.<br>16.2. Монгол Улсын хуулийн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.<br>16.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:<br>16.3.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;<br>16.3.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;<br>16.3.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.<br>16.4. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 14.2, 14.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална. |
| **17. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг** | 17.1. Нийлүүлэхээр санал болгох барааны гарал үүслийн мэдээллийг V бүлгийн Маягт 2-ын холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ.<br>17.2. Хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй. |

17.3. Оролцогчийн санал болгож буй бараа нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар тендерт ирүүлнэ.

17.4. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол оролцогч өөрийн санал болгож байгаа бараанд холбогдох загвар, дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө захиалагчид хүргүүлэх ба шалгалт, туршилтыг хийх ажиллагаанд оролцогчийг өгөгдлийн хүснэгтэд зааснаар оролцуулна.

17.5. Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно. Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн тодорхойлолттой нийцсэн болохыг хянан үзэх боломжтой баримт, хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарласан тайлбар ирүүлсэн байна.

17.6. Барааг нийлүүлснээс хойш өгөгдлийн хүснэгтэд заасан хугацааны туршид тасралтгүй, горимын дагуу ашиглахад шаардагдах өгөгдлийн хүснэгтэд заасан сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалтыг тэдгээрийг авах боломжтой хаяг, үнийн мэдээллийн хамт ирүүлнэ.

17.7. Техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал, тоног төхөөрөмжийн загвар, хэмжих нэгж, стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар зэрэг нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.

17.8. Гадаадын этгээдийн хувьд гэрээний дагуу хийгдэх техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт;

17.9. Монгол Улсын гарал үүсэлтэй бус бараа нийлүүлэхээр санал болгосон оролцогч нь техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээлэл;

17.10. Хуулийн 8.4-т зааснаар давуу эрх тооцуулах барааны Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлснээр Сангийн сайдын баталсан Давуу эрх олгох аргачлал, зааврын дагуу тооцно. Барааны үнийн задаргаанд Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг заагаагүй, эсхүл гарал үүслийг нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх тооцохгүй.

17.11. ТШЗ-ны 1.3-т зааснаар нийлүүлэхээр санал болгох бараа Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Нотлох баримт бичиг ирүүлээгүй тохиолдолд тухайн барааг шаардлага хангаагүй гэж үзнэ.

17.12. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс нийлүүлэхээр санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

**18. Чадавхын болон туршлагын шаардлага**

18.1. Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.

18.2. Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. Тухайн бараа, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

18.3. Түншлэл нь ТШЗ-ны 18.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 18.1-д заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

18.4. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

**19. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**

19.1. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.

19.2. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд заснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

19.3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

**20. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**

20.1. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

**21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**

21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

21.2. Барааны үнийн задаргаанд багц тус бүрийн барааны нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг тусгаж ирүүлнэ.

21.3. Оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 14-т заасан тендер илгээх маягтад заана.

21.4. ТШЗ 21.3-т заасноор үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг тендерийн үнэ гэж үзнэ.

21.5. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.6. Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.

21.7. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.8. ТШЗ-ны 21.2-т заасан барааны үнийн задаргааны нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч тендер илгээх маягтад үнээс зөрүүтэй бол барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендер илгээх маягтын үнэ гэж үзнэ.

21.9. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

**22. Тендерийн валют**

22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

**23. Тендер хүчинтэй байх хугацаа**

23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.

23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

**24. Тендерийн баталгаа**

24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 24.1-д зааснаар ирүүлнэ.

24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

## Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

**25. Тендер баталгаажуулах, илгээх**

25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

**26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**

26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

## Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

**27. Тендерийн талаар тодруулга авах**

27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

**28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх**

28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ.

**29. Тендерийг үнэлэх**

29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.

29.2. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.

**30. Арифметик алдааг залруулах**

30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.

30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

**31. Давуу эрх олгох**

31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн дотоодын бараанд хуулийн 8.4-т зааснаар давуу эрх олгож, дотоодын барааны хэсгийн үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.

31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.

31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.

**32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт**

32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.

**33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**

33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална.

33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.

33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.

**34. Тендерийг эрэмбэлэх**

34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.

**35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах**

35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадална.

35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 19 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 20 дугаар зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.

35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

## Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

**36. Шийдвэр хүргүүлэх**

36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.

**37. Гүйцэтгэлийн баталгаа**

37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

37.2. Гүйцэтгэлийн баталгааг "Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-д нийцүүлэн гаргана.

**38. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах**

38.1. Захиалагч ТШЗ-ны 9.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.

38.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

## II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ӨХ)

| ТШЗ-ны холбогдох заалт | А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ |
|---|---|
| **ТШЗ 1.1** | Захиалагч: ***"Тавантолгой түлш" ХХК*** |
| **ТШЗ 1.1** | Тендер шалгаруулалтын нэр: ***"Цахилгааны материал худалдан авах"*** |
| **ТШЗ 1.1** | Тендерийн урилгын дугаар: ***"ТТТХХК20240102229"*** |
| **ТШЗ 1.2** | Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: ***"Багцгүй"*** |
| **ТШЗ 1.4** | Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: ***"Үгүй"*** |
| **ТШЗ 2.1** | Санхүүжилтийн эх үүсвэр нь: ***"Өөрийн хөрөнгөөр"*** |
| **ТШЗ 2.1** | Нийт төсөвт өртөг: ***1,114,557,171 (Нэг тэрбум нэг зуун арван дөрвөн сая таван зуун тавин долоон мянга нэг зуун далан нэгэн) төгрөг*** |
| **Б. АГУУЛГА** | |
| **ТШЗ 8.1** | Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг:<br>Хаяг: ***Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р баг, Баянбүрд, Баян уулын баруун талд 0 тоот***<br>Утасны дугаар: ***70119400***<br>Цахим шуудангийн хаяг: ***info@ttt.mn*** |
| **ТШЗ 11.1** | Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: ***"Үгүй"*** |
| **В. ТЕНДЕР БЭЛТГЭХ** | |
| **ТШЗ 12.2** | Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл: ***"Монгол хэл"*** |
| **ТШЗ 13.2.2** | Оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэлийг ирүүлнэ. /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/ |
| **ТШЗ 15.1** | Хувилбарт санал ирүүлэхийг: ***"Зөвшөөрөхгүй"*** |
| **ТШЗ 16.2** | -Монгол Улсын хуулийн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ. |
| **ТШЗ 16.3.3** | Тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг |

| | |
|---|---|
| | /Татвар, нийгмийн даатгалын өргүйг тодорхойлох цахим лавлагаа ирүүлнэ. "Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем "www.tender.gov.mn болон" Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем"-ээр дамжуулан Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас шалгана./ |
| **ТШЗ 17.4** | Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж ирүүлэх эсэх: ***"Үгүй"*** |
| **ТШЗ 17.6** | Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх эсэх, ирүүлэх бол хугацаа: ***"Үгүй"*** |
| **ТШЗ 18.1** | Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн шаардлага, шалгуур үзүүлэлт: ***"Шаардахгүй"***<br><br>Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: ***"Шаардана"***<br><br>1. Батлагдсан төсөвт өртгийн 60 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй барааг 2022, 2023 онуудын аль нэг жилд багадаа 1 удаа нийлүүлсэн байх. /Нийт гэрээний доод үнийн дүн төсөвт өртгийн 60%-иас багагүй байх/<br><br>2. Ижил төстэй бараа гэдэгт :<br>Төрөл бүрийн цахилгаан бараа материал нийлүүлэх, цахилгаан тоноглол угсрах нийлүүлэх ажлыг гүйцэтгэсэн байх туршлагыг хамааруулан авч үзнэ.<br><br>3. Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний талаар мэдээллийг V бүлгийн Маягт 3, 5-ын дагуу бэлтгэн ирүүлэх<br><br>4. Нотлох баримт болох бараа нийлүүлсэн гэрээ, бараа хүлээлгэн өгсөн актын хуулбар, тухайн барааг цаг хугацаанд нь чанартай нийлүүлсэн талаарх захиалагчийн тодорхойлолт, И-Баримтыг тус тус хавсаргаж ирүүлнэ.<br><br>/Бараа нийлүүлсэн талаар захиалагчийн тодорхойлолт ирүүлэх ба нийлүүлсэн бараатай холбоотой чанарын шаардлагыг үнэлгээнд харгалзан үзнэ/<br><br>Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шаардлага: ***"Шаардахгүй"***<br><br>Оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага:<br>***Борлуулалтын орлогын хэмжээ:*** Сүүлийн 2 жил буюу 2022, 2023 онуудын аль нэг жилд борлуулалтын орлого нь төсөвт өртгийн 60%-иас багагүй дүнтэй дүйцэхүйц байна. |
| **ТШЗ 18.2** | Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: ***"Шаардахгүй"*** |
| **ТШЗ 19.1** | Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: Тийм. - Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс тендер шалгаруулалт зарласан өдрөөс хойш авсан, шалгах боломжтой QR код бүхий "Зээлийн |

| | |
|---|---|
| | мэдээллийн сангийн тодорхойлолт"-ыг ирүүлнэ. Уг тодорхойлолтод төлөгдөж дуусаагүй зээлийн мэдээлэл "Хэвийн" бус байгаа тохиолдолд татгалзах үндэслэл болно. ("Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт"-ыг www.sainscore.mn, www.burenscore.mn хаягаар хандан авна. Харилцагч банкны тодорхойлолтыг тендерийг үнэлэхэд харгалзан үзэхгүй.)<br>- Санхүүгийн тайланд аудит хийлгэх үүрэгтэй оролцогчийн хувьд аудитын дүгнэлтийг 2022, 2023 он тус бүрээр хавсарган ирүүлэх ба ирүүлээгүй нь татгалзах үндэслэл болно.<br><br>- Сүүлийн 2 жил (2022, 2023)-онуудын жилийн эцсийн санхүүгийн тайлан Сангийн яамны И баланс цахим системд шивэгдэж баталгаажсан байна. (Санхүүгийн тайлан бүртгэлд шивэгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно);<br>- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн дүн: Төсөвт өртгийн 60 хувиас багагүй байна. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр тодорхойлно.<br><br>- Байгууллагын банкин дахь дансны бэлэн мөнгө болон бусад валютын үлдэгдлийн тодорхойлолт /Тендер нээх огнооноос өмнө 7 хоног дотор баталгаажуулсан байх /<br><br>- Арилжааны банкнаас олгох зээлийн мөнгөн дүн бүхий тодорхойлолт ирүүлнэ.<br><br>- Арилжааны банкны судлагдсан зээлийн авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт /"судлагдаж байгаа эсвэл судалж үзнэ" гэсэн тодорхойлолтыг үнэлгээнд харгалзан үзэхгүй ба дээрх тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байх ёстой/ |
| **ТШЗ 20.1** | Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх: ***"Тийм"***<br>*1.* Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар дэлгэрэнгүй танилцуулга, фото зургийг хүснэгтээр бэлтгэж баталгаажуулан ирүүлнэ.<br>*2.* Барааны үнийн задаргаа ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ.<br>*3.* Барааг хүлээлцэх явцад, гэмтэлтэй болон эд анги дутуу бараа бүтээгдэхүүн илэрвэл тус барааг нийлүүлэгч өөрийн зардлаар нөхөн шинээр сольж өгөх, засварлаж өгөхийг баталсан албан мэдэгдэл ирүүлэх.<br>*4.* Ашигтай ажилласан байх жилийн тоо 2022, 2023 онуудад ашигтай ажилласан байх. |

| | |
|---|---|
| | 5. Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлнэ.<br><br>6. Үйлдвэрлэгчийн гэрчилгээ /патент/, хуулбарыг ирүүлнэ. Цахилгаанаар ажилладаг, өндөр өртөг бүхий бараа материалууд дээр шаардлагатай ба бусад нэр төрөл дээр шаардлагагүй.<br><br>7. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл, заалтыг орхигдуулсан, зөрсөн боловч захилагчийн тогтоосон техникийн тодорхойлолтын шаардлагыг үндсэнд нь хангаж байгааг нотолсон мэдэгдлийг баталгаажуулан ирүүлнэ.<br><br>-Оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: ***“Шаардана”*** Оролцогч нь өөрийн болон түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллийг V бүлгийн Маягт 4-ын дагуу ирүүлнэ. |
| **ТШЗ 21.5.** | Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: ***“Тохируулахгүй тогтмол байна”*** |
| **ТШЗ 21.6** | Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: ***“Тийм”***<br>*Incoterms 2020, Delivery Duty Paid* ***(DDP)***<br>***“Тавантолгой түлш ХХК-ийн Зүүн үйлдвэр, Баруун үйлдвэр, Төвийн үйлдвэрийн агуулах”*** |
| **ТШЗ 24.1** | Тендерийн баталгааны дүн: ***Төсөвт өртгийн 0,5 хувиар тооцон ирүүлсэн байх ба гэрээ байгуулж 2 тал батлах хүртэл хүчинтэй байна.*** |
| **Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ** | |
| **ТШЗ 25.5.** | Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: |
| **ТШЗ 26.1.** | Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:<br>Огноо: ***2024 оны 04-р сарын 09-ны өдөр***<br>Цаг: ***09 цаг 00 минут*** |
| **ТШЗ 26.2.** | Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.<br>Огноо: ***2024 оны 04-р сарын 09-ны өдөр***<br>Цаг: ***09 цаг 30 минут***<br>Тендер нээх газрын хаяг: ***Төв аймаг, Сэргэлэн сум 1-р баг, Баянбүрд, Баян уулын баруун тал, Зүүн үйлдвэр А байрны 231 тоот*** |
| **Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ** | |
| **ТШЗ 29.2.** | Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: ***“Үгүй”*** |
| **ТШЗ 31.1.** | Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: |

| | |
|---|---|
| | *"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 8-р зүйлийн 8.4-т заасан нөхцөлийн аль нэгийг хангасан тохиолдолд тооцно.* |
| **ТШЗ 32.1** | Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: ***"Ашиглахгүй"*** |

# III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

**1.Бараа материалын нэр: Зүүн үйлдвэрт авах бараа материалын жагсаалт**

| № | Техникийн өгөгдөл | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Дүйцүүлэх нэршил | Хавсралт зургын дугаар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Конвейерын тэжээлийн кабель | ОХУ үйлдвэрлэсэн КГ-4*4мм | м | 900 | ОХУ-ийн үйлдвэрлэлтэй дүйцэхүйц байх | Зураг1 |
| 2 | Конвейерын тэжээлийн кабель | ОХУ үйлдвэрлэсэн КГ-4*2,5мм хавтгай краны зориулалт бүхий зам дээр гүйдэг | м | 700 | ОХУ-ийн үйлдвэрлэлтэй дүйцэхүйц байх | Зураг2 |
| 3 | Дотоод хэрэгцээний кабель | ОХУ үйлдвэрлэсэн КГ 2*2.5мм | м | 1,200 | ОХУ-ийн үйлдвэрлэлтэй дүйцэхүйц байх | Зураг3 |
| 4 | Хатаагчаас гарах конвейер кабель | ОХУ үйлдвэрлэсэн КГ-4*25мм | м | 450 | ОХУ-ийн үйлдвэрлэлтэй дүйцэхүйц байх | Зураг4 |
| 5 | Утаа сорогч №1 кабель | ОХУ үйлдвэрлэсэн КГ-4*150мм | м | 300 | ОХУ-ийн үйлдвэрлэлтэй дүйцэхүйц байх | Зураг5 |
| 6 | Утаа сорогч №3 кабель | ОХУ үйлдвэрлэсэн КГ-4*50мм | м | 300 | ОХУ-ийн үйлдвэрлэлтэй дүйцэхүйц байх | Зураг6 |
| 7 | Провод кабель | 1х10мм хар өнгөтэй | м | 700 | ОХУ-ийн үйлдвэрлэлтэй дүйцэхүйц байх | Зураг7 |
| 8 | Төгсгөвч | 2.5мм хар | боодол | 4 | цахилгааны стандартын шаардлага хангасан байх | Зураг8 |
| 9 | Төгсгөвч | 10мм сэрээт хар | боодол | 5 | цахилгааны стандартын шаардлага хангасан байх | Зураг9 |
| 10 | Төгсгөвч | 6мм сэрээт хар | боодол | 4 | цахилгааны стандартын шаардлага хангасан байх | Зураг10 |
| 11 | Төгсгөвч | 4мм сэрээт хар | боодол | 4 | цахилгааны стандартын шаардлага хангасан байх | Зураг11 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 12 | Төгсгөвч | 240мм хөнгөн цагаан | ш | 40 | цахилгааны стандартын шаардлага хангасан байх | Зураг12 |
| 13 | Төгсгөвч | 150мм хөнгөн цагаан | ш | 40 | цахилгааны стандартын шаардлага хангасан байх | Зураг13 |
| 14 | Зэс төгсгөвч | ф150 мм диаметртэй | ш | 100 | ОХУ үйлдвэртэй дүйцэх | Зураг14 |
| 15 | Зэс төгсгөвч | 185мм зэс төгсгөвч | ш | 70 | ОХУ үйлдвэртэй дүйцэх | Зураг15 |
| 16 | Цайрдсан төгсгөвч | ф75 хөндлөн огтлолтой зэс төгсгөвч | ш | 180 | New delhi улсын V.C брандын үйлдэртэй дүйцэх | Зураг16 |
| 17 | Цайрдсан төгсгөвч | ф50 хөндлөн огтлолтой зэс төгсгөвч | ш | 190 | New delhi улсын V.C брандын үйлдэртэй дүйцэх | Зураг17 |
| 18 | Дундын зэс хонгио | Ф95мм хөндлөн огтлол | ш | 90 | New delhi улсын V.C брандын үйлдэртэй дүйцэх | Зураг18 |
| 19 | Дундын зэс хонгио | Ф150м хөндлөн огтлол | ш | 80 | New delhi улсын V.C брандын үйлдэртэй дүйцэх | Зураг19 |
| 20 | Дундын зэс хонгио | Ф50мм хөндлөн огтлол | ш | 120 | New delhi улсын V.C брандын үйлдэртэй дүйцэх | Зураг20 |
| 21 | Дундын зэс хонгио | Ф70мм хөндлөн огтлол | ш | 60 | New delhi улсын V.C брандын үйлдэртэй дүйцэх | Зураг21 |
| 22 | Гэрэл прожектор | 600W IP66 220V Led гэрэл | ш | 90 | OSRAM brand дүйцэхүйц байх | Зураг22 |
| 23 | Баганы прожектор | 400W IP-66 220V Led гэрэл | ш | 90 | OSRAM brand дүйцэхүйц байх | Зураг23 |
| 24 | Таазны гэрэл | Таазны гэрэл 1200W IP-66 220V Led гэрэл | ш | 90 | OSRAM brand дүйцэхүйц байх | Зураг24 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 25 | Замын гэрэл | 400W Лед гэрэл зам дагуу суурилагдах зориулалт бүхий IP55 битүүмжтэй | | 40 | OSRAM brand дүйцэхүйц байх | Зураг25 |
| 26 | Клем | 15а 18ш PVC гадаргуутай гаргалгаатай | ш | 300 | Хятадын цахилгааны үндсэн үйлдвэртэй дүйцэх. | Зураг26 |
| 27 | Клем | 630а 4ш гаргалгаатай PVC гадаргуутай | ш | 60 | Хятадын цахилгааны үндсэн үйлдвэртэй дүйцэх. | Зураг27 |
| 28 | Клем | 63а 4ш гаргалгаатай PVC гадаргуутай | ш | 60 | Хятадын цахилгааны үндсэн үйлдвэртэй дүйцэх. | Зураг28 |
| 29 | Клем | 32а 4ш гаргалгаатай PVC гадаргуутай | ш | 90 | Хятадын цахилгааны үндсэн үйлдвэртэй дүйцэх. | Зураг29 |
| 30 | Клем | 16а 4ш гаргалгаатай PVC гадаргуутай | ш | 90 | Хятадын цахилгааны үндсэн үйлдвэртэй дүйцэх. | Зураг30 |
| 31 | Клем | 100а 4ш гаргалгаатай PVC гадаргуутай 100а 4фаз | ш | 60 | Хятадын цахилгааны үндсэн үйлдвэртэй дүйцэх. | Зураг31 |
| 32 | Зэс шинн | Цул зэсээр цутгасан 3х30mm | м | 48 | ОХУ үйлдвэртэй дүйцэхүйц байх | Зураг32 |
| 33 | Зэс шинн | Цул зэсээр цутгасан 4х40mm | м | 30 | ОХУ үйлдвэртэй дүйцэхүйц байх | Зураг33 |
| 34 | Хөнгөн цагаан шинн | Цул хөнгөн цагаанаар цутгасан 120*10мм | м | 30 | ОХУ үйлдвэртэй дүйцэхүйц байх | Зураг34 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 35 | Хөнгөн цагаан шинн | 50*5мм | м | 30 | ОХУ үйлдвэртэй дүйцэхүйц байх | Зураг35 |
| 36 | Тусгаарлагч /изолятор / | 76мм өндөртэй улаан өнгөтэй БНХАУ үйлдвэрлэсэн | ш | 90 | Хятадын цахилгааны үйлдвэртэй дүйцэхүйц байх | Зураг36 |
| 37 | Тусгаарлагч /изолятор / | 40мм өндөртэй улаан өнгөтэй БНХАУ үйлдвэрлэсэн | ш | 90 | Хятадын цахилгааны үйлдвэртэй дүйцэхүйц байх | Зураг37 |
| 38 | Тусгаарлагч /изолятор / | 35мм өндөртэй улаан өнгөтэй БНХАУ үйлдвэрлэсэн | ш | 90 | Хятадын цахилгааны үйлдвэртэй дүйцэхүйц байх | Зураг38 |
| 39 | Хугацааны реле талбайн гэрэлд | CHINT brand Хүчдэл: :50HZ AC 230В Ачаалал 3А-10А 3КВ Удирдлагын программ 8-16 | ш | 10 | Хятадын цахилгааны стандарт үйлдэвэртэй д | Зураг39 |
| 40 | Бууруулагч ТР | DELIXI BK300 380/220 20A | ш | 12 | Хятадын цахилгааны стандарт үйлдэвэртэй д | Зураг40 |
| 41 | Автоматжуулалтын программын update | 6AV2107-0UB00-0BB0 SIMATIC ProDiag for WinCC Runtime Professional программын шинэчилсэн хувилбар | ш | 3 | ProDiag сompани программтаай дүйцэх | Зураг41 |
| 42 | Конвейерийн хазайлт мэдрэгч | Deviation switch троссон таслуур IP-67 хамгаалалт өндөртэй | ш | 6 | ХБНГерман улсын үйлдвэртэй дүйцэх | Зураг42 |
| 43 | Конвейерийн ааарын таслуур | Pull rope switch троссон таслуур IP-67 хамгаалалт өндөртэй | ш | 6 | ХБНГерман улсын үйлдвэртэй дүйцэх | Зураг43 |
| 44 | Автоматжуулалтын PLC | 24в ийн ажиллах RJ2S 8A | ш | 60 | ХБНГермани улсын үйлдвэртэй дүйцэх | Зураг44 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | панелийн Завсарын реле | | | | | |
| 45 | Автоматжуулалтын PLC панелийн Завсарын реле | 220в ийн ажиллах RJ2S 8A | ш | 60 | ХБНГерман улсын үйлдвэртэй дүйцэх | Зураг45 |
| 46 | Доргио мэдрэгч | CV-YD-010 0.8mA/mms Zero Output 4±0.1 mA Full Range Output 20±0.2 mA Output Current Range 4～20m | ш | 4 | ХБНГерман улсын үйлдвэртэй дүйцэх | Зураг46 |
| 47 | Наалддаг хаяг | 2х3.5мм pvc | ш | 1,020 | Хятадын цахилгаан барааны үйлдвэрийн стандартад дүйцэхүйц | Зураг47 |
| 48 | Зүүдэг вирк | 20х45мм pvc | ш | 360 | Хятадын цахилгаан барааны үйлдвэрийн стандартад дүйцэхүйц | Зураг48 |
| 49 | Гуурсан вирк | 1мм | боодол | 4 | Хятадын цахилгаан барааны үйлдвэрийн стандартад дүйцэхүйц | Зураг49 |
| 50 | Усны хамгаалалтай лент | Emergency Repair, Black (25mm) өргөнтэй усны хамгаалалтын лент | ш | 400 | Хятадын цахилгаан барааны үйлдвэрийн стандартад дүйцэхүйц | Зураг50 |
| 51 | Гланд | PG48мм PVC материалтай | ш | 120 | Хятадын цахилгаан барааны үйлдвэрийн стандартад дүйцэхүйц | Зураг51 |
| 52 | Гланд | PG42мм PVC материалтай | ш | 115 | Хятадын цахилгаан барааны үйлдвэрийн стандартад дүйцэхүйц | Зураг52 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 53 | Гланд | PG29мм PVC материалтай | ш | 50 | Хятадын цахилгаан барааны үйлдвэрийн стандартад дүйцэхүйц | Зураг53 |
| 54 | Гланд | PG25мм PVC материалтай | ш | 60 | Хятадын цахилгаан барааны үйлдвэрийн стандартад дүйцэхүйц | Зураг54 |
| 55 | Гланд | PG19мм PVC материалтай | ш | 60 | Хятадын цахилгаан барааны үйлдвэрийн стандартад дүйцэхүйц | Зураг55 |
| 56 | Кемприк | Улаан ногоон шар цэнхэр 36-70 | м | 34 | Хятадын цахилгаан барааны үйлдвэрийн стандартад дүйцэхүйц | Зураг56 |
| 57 | Кемприк | Улаан ногоон шар цэнхэр 24-36 | м | 30 | Хятадын цахилгаан барааны үйлдвэрийн стандартад дүйцэхүйц | Зураг57 |
| 58 | Кемприк | Улаан ногоон шар цэнхэр 14-18 | м | 30 | Хятадын цахилгаан барааны үйлдвэрийн стандартад дүйцэхүйц | Зураг58 |
| 59 | Кемприк | Улаан ногоон шар цэнхэр 11-13 | м | 30 | Хятадын цахилгаан барааны үйлдвэрийн стандартад дүйцэхүйц | Зураг59 |
| 60 | Хуруувч резин | ф150 хар | ш | 100 | ХБНГермани улсын үйлдвэртэй дүйцэх | Зураг60 |
| 61 | Хуруувч резин | ф95 хар | ш | 105 | ХБНГермани улсын үйлдвэртэй дүйцэх | Зураг61 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 62 | Хуруувч резин | ф70 хар | ш | 90 | ХБНГермани улсын үйлдвэртэй дүйцэх | Зураг62 |
| 63 | Хуруувч резин | ф35 хар | ш | 120 | ХБНГермани улсын үйлдвэртэй дүйцэх | Зураг63 |
| 64 | Дундын ком муфьт | Butt Splice Connector, 2.5-4мм AL132:L141WG | ш | 20 | ХБНГермани улсын үйлдвэртэй дүйцэх | Зураг64 |
| 65 | Дундын ком муфьт | Butt Splice Connector, 6-10мм AWG | ш | 20 | ХБНГермани улсын үйлдвэртэй дүйцэх | Зураг65 |
| 66 | Дундын ком муфьт | 1 Connector & 2 Pieces Heat Shrink Tube)10-16мм | ш | 30 | ХБНГермани улсын үйлдвэртэй дүйцэх | Зураг66 |
| 67 | Дундын ком муфьт | 1 Connector & 2 Pieces Heat Shrink Tube)16-25мм | ш | 30 | ХБНГермани улсын үйлдвэртэй дүйцэх | Зураг67 |
| 68 | Дундын ком муфьт | 1 Connector & 2 Pieces Heat Shrink Tube)25-50мм | ш | 30 | ХБНГермани улсын үйлдвэртэй дүйцэх | Зураг68 |
| 69 | 380в мама папа 5 шонтой 63А | 280 Volt 63Amp 5 Pin (3P+E+N) Plugs and Sockets | ш | 80 | ХБНГермани улсын үйлдвэртэй дүйцэх | Зураг69 |
| 70 | 220в мама папа 3 шонтой 32А | 32amp 3 Pin (2P+E) Scame 240 Mains Voltage Plugs, Sockets and Couplers. | ш | 80 | ХБНГермани улсын үйлдвэртэй дүйцэх | Зураг70 |
| 71 | LS Соронзон залгуур 40А | MC-9b - MC-40a 220v LS brand | ш | 30 | БНСолонгос улсын үйлдвэрийн стандартад дүйцэхүйц байх | Зураг71 |
| 72 | LS Соронзон залгуур 63А | MC-9b - MC-63a 220v LS brand | ш | 20 | БНСолонгос улсын үйлдвэрийн стандартад дүйцэхүйц байх | Зураг72 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 73 | Хугацааны реле AT8N | AT8N 24-240VDC /Autonics/ brand | ш | 9 | БНСолонгос улсын үйлдвэрийн стандартад дүйцэхүйц байх | Зураг73 |
| 74 | Автомат | CHINT 25A зам дээр суугддаг 3 фазын | ш | 80 | CHINT үйлдвэрийн стандартай дүйцэх | Зураг74 |
| 75 | Автомат | 32 А зам дээр суугддаг 3 фазын | ш | 75 | CHINT үйлдвэрийн стандартай дүйцэх | Зураг75 |
| 76 | Автомат | 40 А зам дээр суугддаг 3 фазын) | ш | 13 | CHINT үйлдвэрийн стандартай дүйцэх | Зураг76 |
| 77 | Автомат | 63 А зам дээр суугддаг 3 фазын | ш | 45 | CHINT үйлдвэрийн стандартай дүйцэх | Зураг77 |
| 78 | Автомат | 100 А зам дээр суугддаг 3 фазын | ш | 20 | CHINT үйлдвэрийн стандартай дүйцэх | Зураг78 |
| 79 | Автомат | 3p 100A mccb metasoll | ш | 24 | CHINT үйлдвэрийн стандартай дүйцэх | Зураг79 |
| 80 | Автомат | 3p 75A mccb metasoll | ш | 20 | CHINT үйлдвэрийн стандартай дүйцэх | Зураг80 |
| 81 | Блок контакт 2той | LS-brand 2 туйлтай сэлгэн залгагч | ш | 125 | CHINT үйлдвэрийн стандартай дүйцэх | Зураг81 |
| 82 | Блок контакт 4тэй | LS-brand 4 туйлтай сэлгэн залгагч | ш | 125 | CHINT үйлдвэрийн стандартай дүйцэх | Зураг82 |
| 83 | Автомат зам | 1м урттай 100mm Din rail | ш | 30 | Хятадын цахилгаан барааны үйлдвэрийн стандартад дүйцэхүйц | Зураг83 |
| 84 | Хатаагчийн мэдрэгчийн электрон дэлгэц | 220V Oven Temperature Controller REX-C900 Thermocouple PT,K Universal Relay | ш | 15 | PT,K Universal Relay үйлдвэртэй дүйцэх | Зураг84 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 85 | Хатаагчийн мэдрэгч | WRN-1300 Type K Тепмературын хэмжээ-1300 С Урт 35см 2-гаргалгаатай IP-65 битүүмжтэй | ш | 20 | WRN-1300 Type K үйлдвэртэй дүйцэх | Зураг85 |
| 86 | Розетка 3-н эгнээ | Турк 3-н эгнээ IP65 битүүмжтэй байх | ш | 120 | Турк улсын үйлдвэртэй дүйцэх | Зураг86 |
| 87 | Кабель КГ марктай 4*185мм | КГ-4*185мм зэс уяан ОХУ үйлдвэрлэсэн | м | 300 | ОХУ үйлдвэртэй дүйцэхүйц байх | Зураг87 |
| 88 | Цахилгааны самбар | 2100x1200x600mm Давхар хаалгатай IP65 | ш | 6 | Хятадын цахилгааны барааны үйлдвэртэй дүйцэх | Зураг88 |
| 89 | Завсарын реле | honeywell brand 220в 8 хөлтэй | ш | 13 | honeywell brand үйлдвэртэй дүйцэхүйц байх | Зураг89 |
| 90 | Уртасгагч | 50м дамартай уртасгагч 32А чадалтай | ш | 20 | ОХУ үйлдвэртэй дүйцэхүйц байх | Зураг90 |
| 91 | Коретка далдлагч | 2000x80x60мм Саарал өнгийн PVC материалтай | ш | 35 | Хятадын цахилгааны барааны үйлдвэртэй дүйцэх | Зураг91 |
| 92 | Цахилгааны вилька | Турк 3-н эгнээ IP 65 битүүмжтэй байх | ш | 100 | Турк улсын үйлдвэртэй дүйцэх | Зураг92 |

**2. Бараа материалын нэр: Баруун үйлдвэрт авах бараа материалын жагсаалт**

| Баруун үйлдвэрийн 3-р цехийн 1,2,3-р шугам удирдлагын өрөө нэгтгэх ажил | Тоо | |
|---|---|---|

| № | Нэршил | Техникийн тодорхойлолт | Хэмжих нэгж | | Хавсралт зургийн дугаар |
|---|---|---|---|---|---|
| 1 | кабель | кабель кг 3*70+1*35 | метр | 200 | Зураг № 1 |
| 2 | кабель | кабель кг 3*2,5+1*1,5 | Метр | 600 | Зураг № 2 |
| 3 | кабель | зөөлөн зэс кабель 3*2,5 | Метр | 120 | Зураг № 3 |
| 4 | кабель | Кг 3*1,5 зэс, зөөлөн солонгос | Метр | 720 | Зураг № 4 |
| 5 | Кабель | кг 2*2,5 зөөлөн зэс кабель | Метр | 500 | Зураг № 5 |
| 6 | Кабель | кабель кг 4*4 зөөлөн зэс | Метр | 800 | Зураг № 6 |
| 7 | Кабель | Прувод 1*0,75мм | Метр | 400 | Зураг № 7 |
| 8 | прожектор | 220в 50Гц IP67 лед 200вт | Ширхэг | 20 | Зураг № 8 |
| 9 | прожектор | IP67 220В 400Вт лед прожектор | Ширхэг | 80 | Зураг № 8 |
| 10 | прожектор | 220в 50Гц IP67 лед 400вт | Ширхэг | 21 | Зураг № 8 |
| 11 | прожектор | 220в 50Гц IP67 лед 800Вт | Ширхэг | 10 | Зураг № 9 |
| 12 | Гүйдлийн реле дижитал 0-30А | digital electronic overload relay / гүйдлийн дижитал реле/ 0-30А | Ширхэг | 25 | Зураг № 10 |
| 13 | гүйдлийн реле 30-60А | Relay 180-260VAC Digital Electronic Overload Relay Motor Protector Thermal Overload Relay EOCR-SSD (Size : 30-60A) | Ширхэг | 15 | Зураг № 10 |
| 14 | гүйдлийн реле дижитал 30-60А | Relay 180-260VAC Digital Electronic Overload Relay Motor Protector Thermal Overload Relay EOCR-SSD (Size : 30 60A) | Ширхэг | 15 | Зураг № 10 |
| 15 | Гүйдлийн реле дижитал 60-90А | Relay 180-260VAC Digital Electronic Overload Relay Motor Protector Thermal Overload Relay EOCR-SSD (Size : 60-90A) | Ширхэг | 10 | Зураг № 10 |
| 16 | Цахилгаан хөдөлгүүр | 90кВт, 380В, 1490эр/мин, 50Гц, S1, суурьтай ашигт үйлийн коффицент өндөртэй | Ширхэг | 1 | Зураг № 11 |
| 17 | цахилгаан хөдөлгүүр | 75кВт, 380В, 50Гц, S1, IP67 ашигт үйлийн Коэффициент өндөртэй | Ширхэг | 1 | Зураг № 11 |
| 18 | Цахилгаан хөдөлгүүр | 4кВт, 380В, 1460эр/мин, 50Гц, S1, Ашигт үйлийн коэффициент өндөртэй ABB фермийн ба түүнтэй адилтгах. | Ширхэг | 2 | Зураг № 11 |
| 19 | Цахилгаан хөдөлгүүр | 7,5кВт, 380В, 1460эр/мин, 50Гц, S1, IP67, ашигт үйлийн Коэффициент өндөртэй | Ширхэг | 1 | Зураг № 11 |
| 20 | цахилгаан хөдөлгүүр | 18.5кВт, 380В, 1460эр/мин, 50Гц, S1, IP67, ашигт үйлийн Коэффициент өндөртэй | Ширхэг | 1 | Зураг № 11 |
| 21 | цахилгаан хөдөлгүүр | 30кВт, 380В, 1460эр/мин, 50Гц, S1, IP67, ашигт үйлийн Коэффициент өндөртэй | Ширхэг | 1 | Зураг № 11 |
| 22 | Цахилгаан хөдөлгүүр | 45кВт, 380В, 1460Эр/мин, 50Гц, S1, IP67, ашигт үйлийн Коэффициент өндөртэй | Ширхэг | 1 | Зураг № 11 |
| 23 | Цахилгаан хөдөлгүүр | 5,5кВт цахилгаан хөдөлгүүр IP67 S1 1450эр/мин 380В ашигт үйлийн коффицент өндөртэй | Ширхэг | 3 | Зураг № 11 |
| 24 | цахилгаан хөдөлгүүр | 11кВт, 380В, 1460эр/мин, 50Гц, S1, IP67, ашигт үйлийн Коэффициент өндөртэй | Ширхэг | 1 | Зураг № 11 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 25 | давтамж хувиргагч инвертер | Давтамж хувиргагч инвертер 7,5кВт 380В siemens g120xa IOP-2 дэлгэцтэй | Ширхэг | 3 | Зураг № 12 |
| 26 | давтамж хувиргагч инвертер | Давтамж хувиргагч инвертер 37-40кВт 380В siemens g120xa IOP-2 дэлгэцтэй | Ширхэг | 1 | Зураг № 12 |
| 27 | давтамж хувиргагч инвертер | Давтамж хувиргагч инвертер 90кВт 380В siemens g120xa IOP-2 дэлгэцтэй | Ширхэг | 1 | Зураг № 12 |
| 28 | давтамж хувиргагч инвертер | Давтамж хувиргагч инвертер 30кВт 380В siemens g120xa IOP-2 дэлгэцтэй | Ширхэг | 1 | Зураг № 12 |
| 29 | Самбар | цахилгааны самбар өндөр 1800мм өргөн 800мм зузаан 600мм 1800*800*600 IP67 | Ширхэг | 4 | Зураг № 13 |
| 30 | Арчих материал А даавуу | А даавуу тосолгооны арчих материал | боодол | 6 | Зураг № 14 |
| 31 | Кабель багцлагч /5*500/ | 5мм өргөн 500мм урт нэг удаагын | боодол | 100 | Зураг № 15 |
| 32 | кабель багцлагч 2,5*200 | өргөн 2,5мм урт 200мм кабель багцлагч | боодол | 100 | Зураг № 15 |
| 33 | кабель багцлагч 2,5*80 | өргөн 2,5 мм урт 80 мм | боодол | 100 | Зураг № 15 |
| 34 | Контактор 4011 380в | 380в iek chint фермийн | Ширхэг | 30 | Зураг № 16 |
| 35 | Контактор 2510 NC | 380в, IEk, chint | Ширхэг | 40 | Зураг № 16 |
| 36 | Контактор 1810 NC | 380в IEk фермийн | Ширхэг | 40 | Зураг № 16 |
| 37 | Контактор 3210 NC | 380, IEK, chint фермийн | Ширхэг | 40 | Зураг № 16 |
| 38 | Удирдлагын кнопны хаягжуулалт start | 35мм*10мм START бичигтэй | Ширхэг | 300 | Зураг № 17 |
| 39 | Удирдлагын кнопны хаягжуулалт stop | 35мм*10мм STOP бичигтэй | Ширхэг | 300 | Зураг № 17 |
| 40 | цахилгаан барбан | TDY75, 1440эр/мин, 1.25м/с, 380В, 50Гц, урт-600мм диаметр-300мм Ашигт үйлийн коэффициент өндөртэй ABB фермийн ба түүнтэй адилтгах. | Ширхэг | 1 | Зураг № 18 |
| 41 | Цахилгаан барбан | TDY75, 1440эр/мин, 380В, 50Гц, урт-600мм диаметр-300мм 7,5кВт 1,25м/с | Ширхэг | 1 | Зураг № 18 |
| 42 | Цахилгаан барабан | TDY75, 1440эр/мин, 1.25м/с, 380В, 50Гц, урт-750мм диаметр-400мм Ашигт үйлийн коэффициент өндөртэй ABB фермийн ба түүнтэй адилтгах. 11кВт L-750мм D-400 | Ширхэг | 1 | Зураг № 18 |
| 43 | Термопар К кабель | Темпратур хэмжих шатадгүй бүрээстэй 2*1мм | Метр | 1500 | Зураг № 19 |
| 44 | Завсрын реле 220вольт | RXM 220В 10А schieder фермийн 14 шонтой суурьтай | Ширхэг | 40 | Зураг № 20 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 45 | Аваарын кнопны цоож | цахилгааны самбарын аваарын кнопны хамгаалалтын цоож, түгжээ | Ширхэг | 60 | Зураг № 21 |
| 46 | гэрэл 120см 50вт | лед гэрэл 220в 50Гц 60Вт 120см урт | Ширхэг | 20 | Зураг № 22 |
| 47 | 2ф 16А автомат | IEK, Chint фермийн 2 фазын 25А | Ширхэг | 45 | Зураг № 23 |
| 48 | Температур хэмжигч дэлгэц | Чиг үүрэг: Температур, чийгшлийг хэмжих, хянах Температурын хүрээ: 0℃～123℃ Чийгийн хүрээ: 0-99.9% RH Цахилгаан хангамж: AC220V ±15%,50/60Hz. Онцлогууд: Маш сайн урт хугацааны тогтвортой байдал, LCD дэлгэц эсвэл цаг агаарын хамгаалалттай дамжуулагч бүрхэвч, хамгийн их ачаалал 665Ω | Ширхэг | 12 | Зураг № 24 |
| 49 | Цахилгаан хөдөлгүүрийн тусгаарлагч 7.5кВт | Цахилгаан хөдөлгүүрийн кабелийн оруулгын хөдөлгүүрийн гаргалгааны клем холболтын тусгаарлагч | Ширхэг | 25 | Зураг № 25 |
| 50 | Цахилгаан хөдөлгүүрийн тусгаарлагч клем 22кВт | 22кВт Цахилгаан хөдөлгүүрийн кабелийн оруулгын хөдөлгүүрийн гаргалгааны клем холболтын тусгаарлагч | Ширхэг | 30 | Зураг № 25 |
| 51 | Цахилгаан хөдөлгүүрийн тусгаарлагч клем 90кВт | 90кВт Цахилгаан хөдөлгүүрийн кабелийн оруулгын хөдөлгүүрийн гаргалгааны клем холболтын тусгаарлагч | Ширхэг | 10 | Зураг № 25 |
| 52 | Цахилгаан хөдөлгүүрийн тусгаарлагч клем 11кВт | Цахилгаан хөдөлгүүрийн кабелийн оруулгын хөдөлгүүрийн гаргалгааны клем холболтын тусгаарлагч | Ширхэг | 20 | Зураг № 25 |
| 53 | Цахилгаан хөдөлгүүрийн тусгаарлагч клем | 75кВт Цахилгаан хөдөлгүүрийн кабелийн оруулгын хөдөлгүүрийн гаргалгааны клем холболтын тусгаарлагч | Ширхэг | 10 | Зураг № 25 |
| 54 | дохионы гэрэл ногоон | 220в, цахилгааны самбарт суурилдаг | Ширхэг | 40 | Зураг № 26 |
| 55 | дохионы гэрэл шар | 220в, Цахилгааны самбарт суурилдаг солонгос | Ширхэг | 40 | Зураг № 26 |
| 56 | дохионы гэрэл улаан | 220в, цахилгааны самбарт суурилдаг | Ширхэг | 40 | Зураг № 26 |
| 57 | бирк | Өргөн 25мм урт 70мм цагаан өнгтэй | боодол | 40 | Зураг № 27 |
| 58 | Кноп / түлхүүр NC, NO / | мушигдаг хар бариултай NC, NO контакттай | Ширхэг | 80 | Зураг № 28 |
| 59 | Аваарын кнопны хаяг | Цахилгааны самбарын удирдлагын кноп, аваарын кнопны ард нь хавчуулагдаж суурилдаг дотор хэмэжээ Ф16 мм гадна хэмжээ Ф60 [EMERGENCY STOP] | Ширхэг | 100 | Зураг № 29 |
| 60 | Кноп / улаан/ | Ногоон гэрэлтэй NC, NO контакттай | Ширхэг | 40 | Зураг № 30 |
| 61 | Кноп /ногоон/ | Ногоон гэрэлтэй NC, NO контакттай | Ширхэг | 40 | Зураг № 30 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 62 | Автомат 3P 80A жижиг | Автомат 3р 80A зам дээр суудаг жижиг IEk chnt фермийн | Ширхэг | 6 | Зураг № 31 |
| 63 | Удирдлагын самбарын хаягжуулалд | [ Ш1 УС-1] ээс [Ш1 УС-10] хүртлэх 60мм*250мм хэмжээтэй [ Ш2 УС-1] ээс [Ш2 УС-10] хүртлэх 60мм*250мм хэмжээтэй Ш3 УС-1] ээс [Ш3 УС-10] хүртлэх 60мм*250мм хэмжээтэй | Ширхэг | 30 | Зураг № 32 |
| 64 | /Энд хүн ажиллаж байна/ тэмдэг | / ЭНД АЖИЛЛАЖ БАЙНА/ гэсэн бичигтэй аюулгүй ажиллагааны тэмдэг 200*200мм хөлдөдгүй хугардагүй материалаар хийгдсэн | Ширхэг | 10 | Зураг № 33 |
| 65 | Үзүүр төгсгөвч базагч | Шулуун төгсгөвч базагч 0-6мм хүртлэх төгсгөвч базагч | Ширхэг | 10 | Зураг № 34 |
| 66 | Автоматны шин | 3 фазын зам дээр суудаг жижиг автоамтын 3 фазын шин 3P 80A | Ширхэг | 6 | Зураг № 35 |
| 67 | Автоматны шин | 2 фазын жижиг автоматны прмечик шин 2P 63A | Ширхэг | 6 | Зураг № 35 |
| 68 | Төгсгөвч шулуун | 2,5мм кабелийн үзүүр төгсгөвч E буюу шулуун | боодол | 4 | Зураг № 36 |
| 69 | Төгсгөвч Ф6мм Шулуун | Ф6мм кабелийн үзүүр төгсгөвч Шулуун | боодол | 4 | Зураг № 36 |
| 70 | Төгсгөвч шулуун | Ф0,5мм шулуун E буюу шулуун төгсгөвч | боодол | 4 | Зураг № 36 |
| 71 | төгсгөвч Ф6мм SV сэрээ үзүүртэй | ф6 мм кабелийн үзүүрт хийх зориултатай SV буюу сэрээ үзүүртэй | боодол | 4 | Зураг № 37 |
| 72 | төгсгөвч Ф4 мм SV сэрээ үзүүртэй | 4мм кабелийн үзүүрт хийх зориултатай SV буюу сэрээ үзүүртэй төгсгөвч | боодол | 4 | Зураг № 37 |
| 73 | төгсгөвч 2,5ф SV сэрээ үзүүртэй | 2,5мм кабелийн төгсгөвч SV буюу сэрээ үзүүртэй | боодол | 4 | Зураг № 37 |
| 74 | 0.4кВ хуваарилах байгууламжын хаяг | 400*400мм /3-р цехийн 0,4кВ хуваарилах байгууламж/ | Ширхэг | 1 | Зураг № 38 |
| 75 | Автоматны зам | самбарын жижиг автомат суурилдаг төмөр зас | Ширхэг | 6 | Зураг № 39 |
| 76 | Самбар | цахилгааны Самбар 600*400 IP65 | Ширхэг | 4 | Зураг № 40 |

**3. Бараа материалын нэр: Төвийн үйлдвэрт авах бараа материалын жагсаалт**

| № | Техникийн өгөгдөл | Үзүүлэлт | Тоо ширхэг | Нэмэлт шаардлага | Дүйцүүлэх нэршил | Хавсралт зургын дугаар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Зөөврийн гэрэл | 220в /XG-1009/ IP54 | 8ш | 500вт 25.9 x 11.9 x 19.3 инч | | 1 |
| 2 | SELRELAY | SEL-751A | 1ш | Өндрийн | | 2 |
| 3 | Гүйдлийн трансформатор | 6кВ | 3ш | Өндрийн | | 3 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | Төгсгөлийн муфть | 10kw хуурай | 2ш | Өндрийн | | 4 |
| 5 | Тоолуур | DTSD-545S | 1ш | Өндрийн | | 5 |
| 6 | Шин | 80*10 | 20м | Зэс | | 6 |
| 7 | Кембрик | 80*10 | 15м | 3-н өнгийн | | 7 |
| 8 | Инвертер | G120 75-90кВт | 2ш | | Siemens brand дүйцэхүйц байх | 8 |
| 9 | Инвертер | G120 11-15кВт | 5ш | | Siemens brand дүйцэхүйц байх | 9 |
| 10 | Инвертер | G120 7.5-11кВт | 5ш | | Siemens brand дүйцэхүйц байх | 10 |
| 11 | Прожуктор | 800вт ЛЕД | 20ш | Цэгэн IP64 | | 11 |
| 12 | Прожуктор | 600вт ЛЕД | 40ш | Цэгэн IP64 | | 12 |
| 13 | Прожуктор | 400вт ЛЕД | 80ш | Цэгэн IP64 | | 13 |
| 14 | Прожуктор | 200вт ЛЕД | 50ш | Цэгэн IP64 | | 14 |
| 15 | Прожуктор | 50вт ЛЕД | 35ш | Цэгэн IP64 | | 15 |
| 16 | Кабель | КГ3*120+1*49 | 250м | орос | | 16 |
| 17 | Кабель | КГ3*95+1*50 | 400м | орос | | 17 |
| 18 | Кабель | КГ3*70+1*35 | 200м | орос | | 18 |
| 19 | Кабель | КГ3*16+1*6 | 300м | орос | | 19 |
| 20 | Кабель | КГ3*10+1*4 | 200м | орос | | 20 |
| 21 | Кабель | КГ3*6+1*2.5 | 400м | орос | | 21 |
| 22 | Кабель | КГ4*4 | 500м | орос | | 22 |
| 23 | Кабель | КГ3*2.5+1*1.75 | 400м | орос | | 23 |
| 24 | Кабель | КГ2*4 | 600м | орос | | 24 |
| 25 | Кабель | ПВЗ-1*6 | 400м | орос | | 25 |
| 26 | Кабель | ПВЗ-1*4 | 800м | орос | | 26 |
| 27 | Кабель | ПВЗ-1*0.75 | 400м | орос | | 27 |
| 28 | Кабель | КГ2*2.5 | 400м | орос | | 28 |
| 29 | Кабель | КГ-1*35 | 100м | орос | | 29 |
| 30 | Гэрэл | 36В/хос/т лед өдрийн гэрэл IP57 | 50ш | Бүрхүүлтэй | | 30 |
| 31 | Гэрэл | Нүдэн гэрэл 20см/80вт | 40ш | Led | | 31 |
| 32 | Гэрэл | Туузан гэрэл /white/ | 500м | IP64 | | 32 |
| 33 | Гэрэл | 250Вт шонгын гэрлийн толгой | 15ш | Led | | 33 |
| 34 | Гэрэл | 60х60 120вт | 30ш | Дүүжин таазны | | 34 |
| 35 | Туузан гэрлийн залгуур | 220в | 10ш | 16А | | 35 |
| 36 | Разетка | IP64 25A | 100ш | ил | | 36 |
| 37 | Разетка | юниверсаль/220в, 16А/ | 60ш | Ахуйн ил | | 37 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 38 | МаМа ПаПа | 25А 380в | 60ш | IP64 | | 38 |
| 39 | Вилк | 220в 16А | 100ш | IP64 | | 39 |
| 40 | Унтраалга | 220в 16А IP64/ | 5ш | Ил | | 40 |
| 41 | Унтраалга | 220в 16А IP64/ | 5ш | далд | | 41 |
| 42 | Автомат 3Р | /400A/ | 2ш | ВА88-37 | IEK brand дүйцэхүйц байх | 42 |
| 43 | Автомат 3Р | /250A/ | 2ш | ВА88-35 | IEK brand дүйцэхүйц байх | 43 |
| 44 | Автомат 3Р | /160A/ | 4ш | ВА88-33 | IEK brand дүйцэхүйц байх | 44 |
| 45 | Автомат 3Р | /100A/ | 4ш | ВА88-32 | IEK brand дүйцэхүйц байх | 45 |
| 46 | Автомат 3Р | /80A/ | 8ш | ВА88-32 | | 46 |
| 47 | Автомат 3Р | 63A | 30ш | ВА47-29 | IEK brand дүйцэхүйц байх | 47 |
| 48 | Автомат 3Р | 50A | 30ш | ВА47-29 | IEK brand дүйцэхүйц байх | 48 |
| 49 | Автомат 3Р | 40A | 40ш | ВА47-29 | IEK brand дүйцэхүйц байх | 49 |
| 50 | Автомат 3Р | 32A | 40ш | ВА47-29 | IEK brand дүйцэхүйц байх | 50 |
| 51 | Автомат 3Р | 25A | 40ш | ВА47-29 | IEK brand дүйцэхүйц байх | 51 |
| 52 | Автомат 3Р | 16A | 30ш | ВА47-29 | IEK brand дүйцэхүйц байх | 52 |
| 53 | Автомат 2Р | 32A | 40ш | ВА47-29 | IEK brand дүйцэхүйц байх | 53 |
| 54 | Автомат 2Р | 25A | 40ш | ВА47-29 | IEK brand дүйцэхүйц байх | 54 |
| 55 | Автомат 2Р | 16A | 40ш | ВА47-29 | IEK brand дүйцэхүйц байх | 55 |
| 56 | Автомат 1Р | 25A | 40ш | ВА47-29 | IEK brand дүйцэхүйц байх | 56 |
| 57 | Автомат 1Р | 16A | 40ш | ВА47-29 | IEK brand дүйцэхүйц байх | 57 |
| 58 | Автомат 1Р | 5A | 20ш | ВА47-29 | IEK brand дүйцэхүйц байх | 58 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 59 | Пускатель | 6511 /380в/ | 20ш | | IEK brand дүйцэхүйц байх | 59 |
| 60 | Пускатель | 5011/380в/ | 20ш | | IEK brand дүйцэхүйц байх | 60 |
| 61 | Пускатель | 4011 /380в/ | 25ш | | IEK brand дүйцэхүйц байх | 61 |
| 62 | Пускатель | 3210 /380в/ | 40ш | | IEK brand дүйцэхүйц байх | 62 |
| 63 | Пускатель | 2510 /220в/ | 30ш | | IEK brand дүйцэхүйц байх | 63 |
| 64 | Пускатель | 1810 /220в/ | 20ш | | IEK brand дүйцэхүйц байх | 64 |
| 65 | Пускатель | 1210 /220в/ | 20ш | | IEK brand дүйцэхүйц байх | 65 |
| 66 | дамартай уртасгагч | 50метртэй | 4ш | | IEK brand дүйцэхүйц байх | 66 |
| 67 | Гагнуурын массны утас | Кг1*25 | 300м | орос | IEK brand дүйцэхүйц байх | 67 |
| 68 | Хар хоолойны муфть | 22Ф | 40ш | Төгсгөлийн | IEK brand дүйцэхүйц байх | 68 |
| 69 | Хар хоолойны муфть | 16Ф | 40ш | Төгсгөлийн | IEK brand дүйцэхүйц байх | 69 |
| 70 | Даацын хоолой | 300Ф HDPE | 30м | | IEK brand дүйцэхүйц байх | 70 |
| 71 | Кабелийн хударг | МКС-300 | 2ш | Тагтай | IEK brand дүйцэхүйц байх | 71 |
| 72 | Холболтын үүр | 22Ф | 20ш | Төмөр 4-н салаа оролт гаралттай | IEK brand дүйцэхүйц байх | 72 |
| 73 | Лотки | 3000*200*55 | 40м | Тагтай | IEK brand дүйцэхүйц байх | 73 |
| 74 | Лотки | 3000*100*55 | 30м | Тагтай | IEK brand дүйцэхүйц байх | 74 |
| 75 | Гүйдлийн реле | 0-30A EOCR SSD Digital | 40ш | | Schneider brand дүйцэхүйц байх | 75 |
| 76 | Гүйдлийн реле | 10-60A EOCR SSD Digital | 40ш | | Schneider brand дүйцэхүйц байх | 76 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 77 | Гүйдлийн реле | 0-15A EOCR SSD Digital | 40ш | | Schneider brand дүйцэхүйц байх | 77 |
| 78 | Хар хоолой | 16Ф | 6ш | Уян PVC | | 78 |
| 79 | Хар хоолой | 22ф | 6ш | Уян PVC | | 79 |
| 80 | Дохионы гэрэл | шар 220в /AD-22DS | 100ш | фазын | IEK brand дүйцэхүйц байх | 80 |
| 81 | Дохионы гэрэл | ногоон 220в | 100ш | Фазын | IEK brand дүйцэхүйц байх | 81 |
| 82 | Дохионы гэрэл | улаан 22в | 100ш | фазын | IEK brand дүйцэхүйц байх | 82 |
| 83 | Гүйдлийн трасформатор | 400/5A | 12ш | | IEK brand дүйцэхүйц байх | 83 |
| 84 | Гүйдлийн трасформатор | 200/5A | 12ш | | IEK brand дүйцэхүйц байх | 84 |
| 85 | Амперметр | 400A AMP | 10ш | электрон | IEK brand дүйцэхүйц байх | 85 |
| 86 | Амперметр | 200A AMP | 10ш | электрон | IEK brand дүйцэхүйц байх | 86 |
| 87 | Вольтметр | 500в | 10ш | электрон | IEK brand дүйцэхүйц байх | 87 |
| 88 | пуск стоп | APBB-22N | 40ш | | IEK brand дүйцэхүйц байх | 88 |
| 89 | Пуск кноп | LA38-11 | 60ш | | IEK brand дүйцэхүйц байх | 89 |
| 90 | Стоп кноп | LA38-11 | 60ш | | IEK brand дүйцэхүйц байх | 90 |
| 91 | Аваарын кноп | LA38-11ZS | 40ш | | IEK brand дүйцэхүйц байх | 91 |
| 92 | Төгсгөвч /зэс/ | ф120 | 30ш | | IEK brand дүйцэхүйц байх | 92 |
| 93 | Төгсгөвч /зэс/ | ф95 | 30ш | | IEK brand дүйцэхүйц байх | 93 |
| 94 | Төгсгөвч /зэс/ | ф70 | 40ш | | IEK brand дүйцэхүйц байх | 94 |
| 95 | Төгсгөвч /зэс/ | ф50 | 40ш | | IEK brand дүйцэхүйц байх | 95 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 96 | Төгсгөвч /зэс/ | ф35 | 50ш | | IEK brand дүйцэхүйц байх | 96 |
| 97 | Төгсгөвч /зэс/ | ф25 | 50ш | | IEK brand дүйцэхүйц байх | 97 |
| 98 | Төгсгөвч /зэс/ | ф16 | 60ш | | IEK brand дүйцэхүйц байх | 98 |
| 99 | Төгсгөвч /зэс/ | ф10 | 100ш | | IEK brand дүйцэхүйц байх | 99 |
| 100 | Төгсгөвч /зэс/ | ф6 | 200ш | | IEK brand дүйцэхүйц байх | 100 |
| 101 | Төгсгөвч /зэс/ | ф4 | 300ш | | IEK brand дүйцэхүйц байх | 101 |
| 102 | Төгсгөвч /зэс/ | ф2.5 | 500ш | | IEK brand дүйцэхүйц байх | 102 |
| 103 | Төгсгөвч /хөнгөн цагаан/ | ф35 | 30ш | | IEK brand дүйцэхүйц байх | 103 |
| 104 | Төгсгөвч /хөнгөн цагаан/ | ф70 | 30ш | | IEK brand дүйцэхүйц байх | 104 |
| 105 | Гилц /зэс/ | ф120 | 20ш | | IEK brand дүйцэхүйц байх | 105 |
| 106 | Гилц /зэс/ | ф95 | 20ш | | IEK brand дүйцэхүйц байх | 106 |
| 107 | Гилц /зэс/ | ф70 | 20ш | | IEK brand дүйцэхүйц байх | 107 |
| 108 | Гилц /зэс/ | ф50 | 30ш | | IEK brand дүйцэхүйц байх | 108 |
| 109 | Гилц /зэс/ | ф35 | 30ш | | IEK brand дүйцэхүйц байх | 109 |
| 110 | Гилц /зэс/ | ф25 | 30ш | | IEK brand дүйцэхүйц байх | 110 |
| 111 | Гилц /зэс/ | ф16 | 30ш | | IEK brand дүйцэхүйц байх | 111 |
| 112 | Гилц /зэс/ | ф10 | 30ш | | IEK brand дүйцэхүйц байх | 112 |
| 113 | далдлагч | 20мм/10мм | 40ш | IEK | IEK brand дүйцэхүйц байх | 113 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 114 | далдлагч | 30мм/10мм | 30ш | | IEK brand дүйцэхүйц байх | 114 |
| 115 | далдлагч | 50мм/30мм | 12ш | | IEK brand дүйцэхүйц байх | 115 |
| 116 | Завсрын реле | MY4N-J 220в 10A 14pins | 50ш | Суурьтай | IEK brand дүйцэхүйц байх | 116 |
| 117 | Тросс | 10Ф | 2боодол | бүрээстэй | | 117 |
| 118 | Тросс чангалагч | M10*120 | 20ш | | | 118 |
| 119 | Дундын 0.4кВ Муфть | 120-150Ф | 2ш | | | 119 |
| 120 | Дундын 0.4кВ Муфть | 25-70Ф | 2ш | | | 120 |
| 121 | Дундын 0.4кВ Муфть | 50-95Ф | 1ш | | | 121 |
| 122 | Автоматны зам | 1метртэй | 3ш | | IEK brand дүйцэхүйц байх | 122 |
| 123 | Завуд пермучки | 380в-32A 3P | 10ш | | IEK brand дүйцэхүйц байх | 123 |
| 124 | Завуд пермучки | 220в-32A 2P | 11ш | | IEK brand дүйцэхүйц байх | 124 |
| 125 | Хайрцаг | 50x60 IP57 | 5ш | | IEK brand дүйцэхүйц байх | 125 |
| 126 | Хайрцаг | 40x30 IP57 | 6ш | | IEK brand дүйцэхүйц байх | 126 |
| 127 | Хугацааны реле | 220в 10A | 6ш | | IEK brand дүйцэхүйц байх | 127 |
| 128 | 00-н клем | 7P | 10ш | Зэс | IEK brand дүйцэхүйц байх | 128 |
| 129 | излятор | SM25 | 15ш | | IEK brand дүйцэхүйц байх | 129 |
| 130 | Температур мэдрэгч | PT100 | 30ш | | | 130 |
| 131 | Кабель | KVVP Control Cable 4*1,5 | 800м | | | 131 |
| 132 | Cabel galnd | 40Ф | 30ш | | IEK brand дүйцэхүйц байх | 132 |
| 133 | Cabel galnd | 32Ф | 40ш | | IEK brand дүйцэхүйц байх | 133 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 134 | Cabel galnd | 28Ф | 50ш | | IEK brand дүйцэхүйц байх | 134 |
| 135 | Cabel galnd | 22Ф | 80ш | | IEK brand дүйцэхүйц байх | 135 |
| 136 | Cabel galnd | 16Ф | 80ш | | IEK brand дүйцэхүйц байх | 136 |
| 137 | Cabel galnd | 10Ф | 80ш | | IEK brand дүйцэхүйц байх | 137 |
| 138 | Буурууллагч | 220-12в 16А | 4ш | | | 138 |
| 139 | Гэрэл | 12в, 5Вт лед туузан | 60м | хамгаалалттай | | 139 |
| 140 | Агааржуулалтын сэнс | VKMZ200 | 4ш | 200mm | | 140 |
| 141 | Хомут /тогтоогч/ | 40Ф | 100ш | | | 141 |
| 142 | Хомут /тогтоогч/ | 32Ф | 100ш | | | 142 |
| 143 | Хомут /тогтоогч/ | 28Ф | 100ш | | | 143 |
| 144 | Хомут /тогтоогч/ | 22Ф | 200ш | | | 144 |
| 145 | Хомут /тогтоогч/ | 16Ф | 200ш | | | 145 |
| 146 | Хомут /тогтоогч/ | 10Ф | 100ш | | | 146 |
| 147 | Аваарын гэрэл | ДП2104 | 50ш | цэнэглэдэг | | 147 |
| 148 | EXIT гэрэл | CCA-1001 | 15ш | цэнэглэдэг | | 148 |
| 149 | Хөргөлтийн сэнс | 110кВтын хөдөлгүүрийн G325 | 4ш | G325 | | 149 |
| 150 | Хөргөлтийн сэнс | 11кВтын хөдөлгүүрийн G160 | 20ш | G160 | | 150 |
| 151 | Хөргөлтийн сэнс | 2.2кВтын хөдөлгүүрийн G100 | 5ш | G100 | | 151 |
| 152 | Төгсгөлийн концвек | 220в-5А | 40ш | | | 152 |
| 153 | Гэрэл | Т4- 60см 20w | 40ш | | | 153 |
| 154 | Клем | 55-75кВт-н хөдөлгүүрийн холболтын | 5ш | | | 154 |
| 155 | Клем | 18-22кВт-н хөдөлгүүрийн холболтын | 10ш | | | 155 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 156 | Клем | 11-15кВт-н хөдөлгүүрийн холболтын | 25ш | | | 156 |
| 157 | Клем | 5.5-7.5кВт-н хөдөлгүүрийн холболтын | 20ш | | | 157 |
| 158 | Клем | 3кВт-н хөдөлгүүрийн холболтын | 5ш | | | 158 |
| 159 | Потинциометр | 10к ОМ WH148 | 20ш | | | 159 |
| 160 | Доргиур | 0.75кВт | 2ш | | | 160 |
| 161 | Мөөгөн сорох сэнс | 220в | 20ш | | | 161 |
| 162 | Багцлагч | 300мм | 20ш | | IEK brand дүйцэхүйц байх | 162 |
| 163 | Багцлагч | 200мм | 20ш | | IEK brand дүйцэхүйц байх | 163 |
| 164 | Багцлагч | 150мм | 15ш | | IEK brand дүйцэхүйц байх | 164 |
| 165 | Багцлагч | 100мм | 10ш | | IEK brand дүйцэхүйц байх | 165 |
| 166 | Цайрдсан трубо | 16Ф 3метртэй | 80ш | нимгэн | | 166 |
| 167 | Цайрдсан трубо | 22Ф | 100ш | нимгэн | | 167 |
| 168 | Цайрдсан трубоны булан | 16Ф | 40ш | нимгэн | | 168 |
| 169 | Цайрдсан трубоны тогтоогч | 16Ф | 100ш | нимгэн | | 169 |
| 170 | Цайрдсан трубоны булан | 22Ф | 40ш | нимгэн | | 170 |
| 171 | Цайрдсан трубоны тогтоогч | 22Ф | 100ш | нимгэн | | 171 |
| 172 | Төмөр кроп | тагтай | 100ш | 80мм | | 172 |
| 173 | Хомут | 8мм | 100ш | | | 173 |
| 174 | Хар хавтан | 240*120см | 10ш | Зузаан 10мм | | 174 |

## Бараа нийлүүлэлтийн хуваарь

| № | Барааны нэр | Тоо хэмжээ | Хэмжих нэгж, тун | Өгөгдлийн хүснэгтэд заасан барааг хүргэх эцсийн цэг | Бараа нийлүүлэх хугацаа | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа) | Нийлүүлэгчийн санал болгох хугацаа *(Оролцогч энэ баганыг бөглөнө)* |
| *1* | *2* | *3* | *4* | *5* | *6* | *7* |
| 1 | *Зүүн үйлдвэрт авах бараа материал / бараа материалын задаргааг зүүн үйлдвэрийн техникийн тодорхойлолтоос харах/* | | | *Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р баг, Баянбүрд, Баян уулын баруун талд 0 тоот* | *Гэрээ байгуулсан өдрөөс хойш хуанлын 45 хоногт* | |
| 2 | | | | | | |
| 3 | | | | | | |
| 4 | *Баруун үйлдвэрт авах бараа материал /бараа материалын задаргааг барууб үйлдвэрийн техникийн тодорхойлолтоос харах/* | | | *СХД 20-р хороо Тавантолгой түлш ХХК-ийн Баруун бүсийн үйлдвэрийн байр* | *Гэрээ байгуулсан өдрөөс хойш хуанлын 45 хоногт* | |
| 5 | | | | | | |
| 6 | | | | | | |
| 7 | *Төвийн үйлдвэрт авах бараа материал /бараа материалын задаргааг төвийн үйлдвэрийн техникийн тодорхойлолтоос харах/* | | | *Тавантолгой түлш ХХК Төвийн үйлдвэр БГД 20-р хороо ДЦС2-ийн зүүн талд* | *Гэрээ байгуулсан өдрөөс хойш хуанлын 45 хоногт* | |
| 8 | | | | | | |
| 9 | | | | | | |

# V БҮЛЭГ.ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТУУД

Маягт 1.Тендер илгээх маягт

Маягт 2.Барааны үнийн задаргаа

Маягт 3.Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл

Маягт 4.Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Маягт 5.Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Маягт 6.Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

Маягт 1 **Тендер илгээх маягт**

***[огноо]***

***“Тавантолгой түлш” ХХК*-д**

Манай ***[оролцогчийн нэр]*** нь танай байгууллагаас зарласан ***[тендер шалгаруулалтын нэр, дугаар]*** тендер шалгаруулалтад ***[үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр]*** төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “**тендер**” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцохтой холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна. Үүнд:

   2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;

   2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;

   2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй;

   2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт ***[“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих]***. ***[Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих]***.
5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш ***ажлын 30*** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

***[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,***
***эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,***
***албан тушаал, гарын үсэг,***
***байгууллагын тамга, тэмдэг]:***
***Хаяг:***

Маягт 2 **Барааны үнийн задаргаа**

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **№** | **Барааны нэр** | **Гарал үүслийн улс[1]** | **Тоо хэмжээ** | **Хэмжих нэгж, тун** | **Нэгж үнэ** | **Нэр төрөл бүрийн бүгд үнэ (4x6)** | **Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ** | **Бараа нийлүүлэхэд ногдох татвар, хураамж** | **Нэр төрөл бүрийн нийт үнэ (7+8+9)** | **Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх[2]** |
| 1 | | | | | | | | | | *Тийм/Үгүй* |
| 2 | | | | | | | | | | |
| ... | | | | | | | | | | |
| | **Тендерийн нийт үнэ** | | | | | | | | | |

***[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,***

***эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,***

***албан тушаал, гарын үсэг, байгууллагын***

***тамга, тэмдэг]:***

[1] ТШЗ-ны 18.6.2-ын дагуу ирүүлсэн баримт бичигт дурдсан барааны гарал үүслийн талаарх мэдээлэлтэй ижил байна.
[2] Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх гэдэгт “тийм” гэж бөглөсөн бол түүнийг нотлох баримт бичгийг хавсаргана.

Маягт 3 **Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл**

| Гэрээний нэр | Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас | Төсөвт өртөг | Хугацаа /эхэлсэн, дууссан/ |
|---|---|---|---|
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

Маягт 4 **Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл**

| Гэрээний нэр | Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас | Төсөвт өртөг | Гэрээ эхэлсэн хугацаа | Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

Маягт 5 **Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл**

| |
|---|
| Оролцогчийн нэр: *[түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].* |

| | |
|---|---|
| 1. | Захиалагчийн нэр |
| 2. | Гэрээний нэр |
| 3. | Гэрээний дугаар |
| 4. | Гэрээ байгуулсан огноо |
| 5. | Гэрээ дуусгавар болсон огноо |
| 6. | Гэрээний дүн |
| 7. | Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил |
| | Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох)<br>□Үндсэн нийлүүлэгч □Түншлэлийн гишүүн □Туслан гүйцэтгэгч |

Маягт 6 **Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт**

| | **Нууцалсан баримт бичиг, мэдээлэл** | **Хүний эмзэг мэдээлэлд хамаарах хууль зүйн үндэслэл** |
|---|---|---|
| 1. | | |
| 2. | | |
| 3. | | |
| 4. | | |
| 5. | | |

# VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

## Санамж

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж бараа худалдан авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас бараа, түүнтэй холбогдох үйлчилгээг худалдан авах харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн бараа худалдан авах нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн бараа худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. ГТН-д заасан зарим жишээ, нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
7. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан гэрээ байгуулах албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалттай танилцаж, судалсан байх шаардлагатай болохыг анхаарна уу.

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

## НЭГ.ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:

1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;

1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;

1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;

1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;

1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нэрлэснийг;

1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;

1.1.7. “Бараа нийлүүлэх нөхцөл” гэж Захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцүүлж Тендерт тусгасан бараа бэлтгэх, нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг ойлгоно. Тендерт тусгайлан заагаагүй бараа нийлүүлэх нөхцөлийг Техникийн тодорхойлолтод тусгаснаар ойлгоно. Хуулийн 30.2, 34.2-т заасныаар хэлэлцээ хийсэн тохиролцоо нь Гэрээнд тусгагдсан бол Бараа нийлүүлэх нөхцөлийн нэг хэсэг болно.

1.1.8. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;

1.1.9. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;

1.1.10. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;

1.1.11. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацааг;

1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй

харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;

1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;

1.1.14. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал“ гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

Гэрээний тайлбар

1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:

1.2.1. Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.

1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.

1.2.3. Зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.

1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.

1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

## ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ

Бараа нийлүүлэх

2.1 Нийлүүлэгч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.

2.2 Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй

шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна.

2.3 ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.

2.4 Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.

**Бараа нийлүүлэх газар**

2.5 Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.

**Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах**

2.6 Бараа нийлүүлэх хугацааг нийлүүлэлтийн хуваарийг үндэслэн ГТН-д заана.

2.7 Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:

2.7.1 Захиалагч ГЕН-ийн 2.4-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;

2.7.2 Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон.

2.8 Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.

2.9 ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй.

**Барааг хүлээлгэн өгөх**

2.10 Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.

2.11 Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ.

**Барааны гарал үүслийн улс**

2.12 Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна.

2.13 Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь заавал Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна.

**Баглаа боодол**

2.14 Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдлоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хангана.

2.15 Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа боодолд хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно.

2.16 Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрдөнө.

Худалдааны нөхцөл

2.17 Гэрээнд Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хэрэглэх бол тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 20.6-д заасан нөхцөлийг ГТН-д тусгана.

2.18 ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.

Гүйцэтгэлийн баталгаа

2.19 Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Нийлүүлэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Нийлүүлэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.

2.20 Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Нийлүүлэгчийн Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна:

2.20.1 Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;

2.20.2 Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;

2.20.3 Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.

2.21 Захиалагч гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Нийлүүлэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.

2.22 ГЕН-ийн 2.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Нийлүүлэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.

2.23 Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 4.11-д заасан Чанарын баталгаа гаргасан тохиолдолд Гүйцэтгэлийг баталгааг чөлөөлнө.

## ГУРАВ. ЗАХИАЛАГЧ

Барааг хүлээн авах

3.1 Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.

Шалгалт, туршилт

3.2 Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ.

3.3 Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ.

3.4 ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна.

3.5 Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.

3.6 Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.

Гэрээний үнэ

3.7 Гэрээний үнийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.

3.8 Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д заана.

Төлбөр төлөх

3.9 Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө.

3.10 Нийлүүлэгчийн хүсэлтээр Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг ГЕН-ийн 2.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.

3.11 Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.

3.12 Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.

3.13 ГЕН-ийн 3.8-д заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.

3.14 Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

3.15 Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана.

## ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА

Захиалагчийн хүлээх эрсдэл

4.1. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:

4.1.1. Барааг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан;

4.1.2. Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаарахгүй) байх хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан.

Даатгал

4.2. Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж, даатгалын

гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна.

Доголдол

4.3. Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ.

4.4. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй.

4.5. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө.

4.6. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.

4.7. Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.

4.8. Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө.

4.9. Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас суутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө.

Чанарын баталгаа

4.10. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-д заана.

4.11. ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно.

4.12. Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно.

4.13. ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.

4.14. Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.

4.15. ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно.

4.16. ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.

Алданги

4.17. Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд хугацаа

хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.

4.18. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнө.

Оюуны өмчийн эрх зөрчих

4.19. Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.

Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал

4.20. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.10-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.

4.21. Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.

4.22. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.

4.23. Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Нийлүүлэгч ГЕН-ийн 2.7-д заасан хүсэлт гаргаж болно.

Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа

4.24. Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.

4.25. Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд эсхүл Нийлүүлэгч ГЕН-ийн 2.13-т заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.

## ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл

5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй:

5.1.1. Нийлүүлэгч гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч нэмэлт хугацаанд гүйцэтгээгүй;

5.1.2. Бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;

5.1.3. Нийлүүлэгч ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн нь тогтоогдсон.

5.1.4. Нийлүүлэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй.

5.2. Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авлига өгсөн, залилах гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.

5.3. Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.

5.4. Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.

Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэл

5.5. Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.

**ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ**

Төлөөлөгч

6.1. Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.

6.2. Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.

6.3. Гэрээ хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.

6.4. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

Туслан гүйцэтгэгч

6.5. Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт зааснаас илүү хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.

6.6. Туслан гүйцэтгэгчийн аливаа зөрчлийг (хугацаа хэтрүүлэх, ажлын доголдол гэх мэт) Нийлүүлэгч хариуцах бөгөөд Туслан гүйцэтгэгч өөрчлөгдсөн тохиолдолд ГЕН-ийн 2.3-д заасан журмыг баримтална.

Нууцлал

6.7. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал

зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.

6.8. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.

**Мэдэгдэл**

6.9. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.

6.10. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.9 -д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.

6.11. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.

6.12. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:

6.12.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шуудanд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн;

6.12.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.

6.13. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

6.14. ГЕН-ийн 6.13-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.

**Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах**

6.15. Дараах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна:

6.15.1. ГЕН-ийн 2.8-т заасны дагуу хугацаа сунгагдсан;

6.15.2. үнийн тохируулга хийсэн.

6.16. Гэрээний нэмэлт, өөрчлөлтөд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

6.17. ГЕН-ийн 6.15-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.

**Маргаан шийдвэрлэх**

6.18. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

6.19. Талууд зөвшилцөн, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

| | |
|---|---|
| **ГЕН 2.5.** | Бараа нийлүүлэх газар**: *“Тавантолгой түлш” ХХК-ийн Зүүн үйлдвэр, Төвийн үйлдвэр, Баруун үйлдвэрийн байранд тус тусад нь техникийн тодорхойлолтын дагуу*** |
| **ГЕН 2.6.** | Бараа нийлүүлэх сүүлийн хугацаа: ***Гэрээ байгуулсан өдрөөс хойш хуанлын 45 хоногт***<br>Барааг үе шаттай нийлүүлэх бол үе шатны хугацаа*:* ***Шаардахгүй*** |
| **ГЕН 2.10.** | Бараа хүлээлгэн өгөх нөхцөл:<br>*Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газар /Зүүн, Төвийн, Баруун үйлдвэрийн агуулах/-т хүргүүлнэ.*<br>Бараанд холбогдох баримт бичиг: ***Чанарын шаардлагад нийцсэн эсэхийг нотлох баримт, гарал үүслийн гэрчилгээ г.м***<br>*Барааг “Тавантолгой түлш” ХХК-ийн хашаанд ирсэний дараа тус компанийн холбогдох чанарын хяналт, нөөц хангамжын мэргэжилтэнүүд, холбогдох инженер техникийн ажилтан техникийн шаардлагыг хангасан гэж үзсэн тохиолдолд барааг хүлээн авна.* |
| **ГЕН 2.14.** | Баглаа, боодол:<br>*Барааг тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэн эцсийн цэгт хүргэнэ. Тээвэрлэх, хадгалах үедээ ус бороо, галын аюулаас бүрэн хамгаалагдсан зориулалтын саванд хийж барааны чанарыг алдагдуулахгүй байна.* |
| **ГЕН 2.17.** | Худалдааны нөхцөл:<br>***Incoterms 2020, Delivery Duty Paid (DDP)***<br>***“Тавантолгой түлш” ХХК-ийн Зүүн үйлдвэр, Төвийн үйлдвэр, Баруун үйлвэрийн агуулах*** |
| **ГЕН 3.8.** | Үнийн тохируулга хийх аргачлал: ***Тохируулахгүй тогтмол байна*** |
| **ГЕН 3.9.** | Төлбөр төлөх хугацаа:<br>***Нийлүүлэлтийн гүйцэтгэлээр санхүүжигдэнэ.*** |
| **ГЕН 4.2.** | Даатгал:<br>***Шаардлагатай тохиолдолд нийлүүлэгч хариуцна.*** |
| **ГЕН 4.10.** | Баталгаат хугацаа: ***Зарим өндөр үнийн дүн бүхий бараа материал дээр гэрээ байгуулахаас өмнө нийлүүлэгч талтай харилцан зөвшилцөж гэрээнд тусгана.*** *(Барааг ашиглаж эхэлснээс хойш доголдол илэрсэн тохиолдолд нийлүүлэгч өөрийн хөрөнгөөр сольж, засварлана)* |
| **ГЕН 4.11** | Чанарын баталгаа: Тийм***.*** *(Инвертер, цахилгаан хөдөлгүүр)* |
| **ГЕН 4.17.** | Нийлүүлэгчийн төлөх алданги**:**<br>Алданги тооцох эсэх**: *“Тийм”***<br>Алдангийн хувь**: *Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувь.*** |
| **ГЕН 4.18.** | Захиалагчийн төлөх алданги:<br>Алданги тооцох эсэх**: “Үгүй”** |

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

***[Тендер шалгаруулалтын нэрийг бичих]*** гэрээ.
Дугаар № ***[Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]***

.............................. хот/аймаг

Нэг талаас ***[захиалагчийн нэрийг бичих]*** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэрийг бичих]** (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь ***[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]*** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.

2. Гэрээний үнийг Нийлүүлэгч ***[Нийлүүлэгчийн нэрийг бичих]***-ийн харилцах ***[Банкны нэрийг бичих]*** банкны ***[дансны дугаар бичих]*** дугаар дансанд шилжүүлнэ.

3. Доор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
   - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
   - 3.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;
   - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
   - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
   - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
   - 3.6. Техникийн тодорхойлолт;
   - 3.7. Бараа нийлүүлэлтийн хуваарь.

4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
   - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
     Эцэг/эх-ийн нэр:
     Нэр:
     Албан тушаал:
     Ажлын утас:
     Гар утас:
     Цахим шуудан:

   - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
     Эцэг/эх-ийн нэр:
     Нэр:
     Албан тушаал:
     Ажлын утас:

Гар утас:
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_______________

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] ______________

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

| | |
|---|---|
| Огноо: | ***2024.04.09*** |
| Тендер шалгаруулалтын төрөл: | ***Бараа*** |
| Тендер шалгаруулалтын нэр: | ***Цахилгааны материал худалдан авах*** |
| Тендер шалгаруулалтын дугаар: | ***ТТТХХК/20240102229*** |
| Нийт төсөвт өртөг: | ***1,114,557,171*** |
| Тендер шалгаруулалтын арга: | ***Нээлттэй*** |

1. ***“Тавантолгой түлш” ХХК*** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.

2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: ***“Багцгүй”***

3. Тендерийг ***2024 оны 04-р сарын 09-ны өдрийн 09.00 цагаас*** өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг ***2024.04.09****-ны өдрийн*, ***09 цаг 30 минутад*** нээнэ.

4. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: ***“Зөвшөөрөхгүй”***
5. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: ***“Эрхгүй”***
6. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байна.

7. Тендерийн баталгаа шаардах эсэх: ***“Тийм”***
   Тендерийн баталгаа шаардах бол тендер шалгаруулалтын баримт бичгийн заасан үнийн бүхий тендерийн баталгааг холбогдох журмын дагуу цахим системээр ирүүлснээр тендер нээх болохыг анхаарна уу.

8. Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: ***“Үгүй”***

9. Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: ***“Үгүй”***

10. Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

***Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р баг, Баянбүрд, Баян уулын баруун талд, Зүүн үйлдвэр төв байрны 101 тоот, Худалдан авах ажиллагааны хэлтэс,***
***Утас: 77119400, Цахим шуудангийн хаяг: info@ttt.mn***